

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД	%	Хойш
Л.Хүрэлбаатар	70%	2012
Олон нийт	30%	2019

ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Ердийн гишүүн	6
Хараат бус гишүүн	5

Менежмент:

Гүйцэтгэх захирал: А.Отгондарь

/23+ жилийн туршлага/

Linkedin: Otgondari Agvaandorj

Гүйцэтгэх удирдлагын баг:

16 гишүүн

Ажилтны тоо: 265

Эрэгтэй 55%, Эмэгтэй 45% /дундаж нас 35/

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ХАРЬЦАА

Харьцаа	2023	2024
ROE	15.8%	17.2%
ROA	4.5%	6.9%
Нийт ашгийн маржин	44.4%	45.7%
Цэвэр ашгийн маржин	11.0%	10.7%
Өрийн харьцаа	72.0%	60.0%

2024 ОНЫ ОНЦЛОГ ҮЙЛ ЯВДАЛ

- Шингэн болон хуурай хүнсний үйлдвэрийг нэгтгэсэн нийт 6,300м2 MFC 2.0 үйлдвэр ашиглалтад оров.
- Компанийн засаглал, хараат бус хяналтыг сайжруулж, ТУЗ-ийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн хараат бус 5 гишүүнтэй болов.
- Швейцарт төвтэй аудит, магадлан итгэмжлэлийн SGS байгууллагын өндөр шалгуурыг давж, олон улсын стандартуудыг амжилттай хэрэгжүүлснээ баталгаажуулав.
- Төв Азийн зах зээл рүү бизнесээ тэлж, экспортоо нэмэгдүүлэв.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Эрчим хүч: Эрчим хүчний хэрэглээгээ автоматаар тохируулдаг инвертертэй тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Нарны эрчим хүч: ашиглан орчны гэрэлтүүлгийг шийдэж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжийг нэмэгдүүллээ.

Хуванцрын хэрэглээ: "Экос" ус, "Энхжин" цайны савлагааг шинэчилж хуванцрын хэмжээ, цаасны хэрэглээг бууруулснаар жилд 51 тонн хог хаягдал гарахаас сэргийлж ажиллаа.

Саарал усны дахин ашиглалт: Цэвэр усны хэрэглээг бууруулж, үйлдвэрийн цэвэрлэгээ, ахуйн хэрэглээ, ногоон байгууламжийн усалгаанд саарал ус ашиглаж байна.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН НИЙЦЭЛ

ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо)

FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал)

ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлага)

ISO 17025 (Лаборатори)




КОМПАНИЙН ТУХАЙ

Монос Группийн охин компани болох Монос Хүнс ХК нь 2012 онд хүн амын эрүүл мэндийг дэмжих хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаалах зорилгоор байгуулагдсан. Группийн үйл ажиллагааны нэг чиглэл нь эрдэм шинжилгээ, судалгаа байдаг тул Монгол орны хөрсөнд ургасан байгалийн түүхий эдийг ашиглан олон жилийн судалгаанд үндэслэн хүний биед ээлтэй, эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг. Монос Хүнс ХК нь нийт 13 брэндийн 71 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж Монголдоо төдийгүй олон улсад нийлүүлдэг үндэсний үйлдвэрлэгч юм. Ингээд компани 2019 онд нээлттэй хувьцаат компани болсноос хойш хувьцаа эзэмшигчдийн тоо 5 дахин өсөж 15 мянгад хүрсэн нь хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдийн итгэлийг хүлээн, найдвартай үйл ажиллагаа явуулж тогтмол өсөж ирснийг илтгэж байна.



БОРЛУУЛАЛТ

Тэрбум ₮	2022	2023	2024	YoY%
Борлуулалтын орлого	28.2	31.7	38.0	+ 20%
Борлуулалтын өртөг	15.9	17.2	19.7	+ 15%
Нийт ашиг	12.3	14.5	18.3	+ 26%
Цэвэр ашиг	3.2	3.5	4.1	+ 16%



Компанийн орлогын харьцааны хувьд шингэн хүнс 75%, хуурай хүнс 25%-г бүрдүүлдэг бөгөөд шингэн хүнсний хувьд Монос Хүнс ХК 2024 онд 10 сая литр бүтээгдэхүүн борлуулсан байна. Нийт борлуулалтын орлого 20% өссөн ба өсөлтийн хувиар МААМУУ брэнд (+52.7%), үүнийн дүнгээр Экос ус (+₮3.4 тэрбум) хамгийн их борлуулалт нэмэгдсэн байна.

ХУВЬЦААНЫ ТАЛААР

Хувьцааны ханш +27% ₮70.00 vs ₮88.89 (IPO үнэ) (2024.12.31)	P/E ratio: 8.91 P/B ratio: 1.54 (2024.12.31)
--	--



ЯАГААД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

Тогтвортой өсөлттэй бизнес модель:

Олон жил тогтвортой өсөлттэй ажиллаж, зах зээлд байр сууриа бататгасан. Үйлдвэрлэлийн хүчин чадлаа 3 дахин нэмэгдүүлсэн ба дэлхий даяар хурдацтай өсөж буй эрүүл хэрэглээг дэмжих бизнесийн философийг суурь болгон, ашигт ажиллагааг тогтмол нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Ногдол ашиг тогтмол тараадаг: 2019 онд IPO хийснээс хойш 2019-2022, 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн бөгөөд нийт ₮4.1 тэрбумыг ногдол ашигт олгоод байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тэрбум ₮	2022	2023	2024	YoY%
Нийт хөрөнгө	36.5	77.3	59.0	-24%
Эргэлтийн хөрөнгө	12.5	39.2	17.6	-55%
Урт хугацаат өр төлбөр	5.8	35.8	16.0	-55%
Нийт өр төлбөр	19.2	55.3	35.4	-36%
Өөрийн хөрөнгө	17.3	22.0	23.6	+ 7%

• Зах зээлд бүтээгдэхүүний эрэлт нь нийлүүлэлтийн боломжоос давж борлуулалтын өсөлтийн хурд 2022 оноос саарч ирсэн бөгөөд хүчин чадлаа нэмэх зорилгоор 2023 онд ₮27 тэрбумын урт хугацаат зээл авч шинэ үйлдвэрт хөрөнгө оруулалт хийсэн.

• Компани богино хугацаанд өрийн дарамтаас гарах бодлого баримтлан ашигт ажиллагааг нэмэгдүүлэн 2024 онд ₮20 тэрбумын урт хугацаат зээлийг эргэн төлснөөр эргэлтийн хөрөнгө 55% буурсан үзүүлэлттэй гарсан байна.

• 2024 онд MFC 2.0 шинэ үйлдвэр ашиглалтад орсноор үйлдвэрлэлийн хүчин чадал 3 дахин нэмэгдэн, цаашид бүтээгдэхүүний төрөлжилт, борлуулалтын орлого нэмэгдэн, бизнесийн өсөлтийг тогтмол хадгалах төлөвтэй байна.

Зах зээлийн үнэлгээ 2024 оны сүүлийн байдлаар **₮36.3 тэрбум.**

• Хувьцааны өдрийн дундаж арилжааны хэмжээ **₮6.8 сая.**

• Хувьцааны ханшийн хувьд Ковидын дараа буюу 2022 оны II сард түүхэн **дээд ханш ₮149.70-д** хүрч байсан бол сүүлийн 52 долоо хоногийн ханшийн хэлбэлзэл нь ₮77.46 - ₮96.61 хооронд байлаа.

• Тархалтын судалгаагаар хувьцаа эзэмшигчдийн дийлэнх нь **35-с дээш насны иргэд** буюу эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийн эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүн түлхүү сонгодог хэрэглэгчдийн сегмент байна.

Инновацилаг: Шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлт тогтмол хийдэг, бүх насны хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүний төрлүүдтэй. 2025 онд шинээр 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахаар төлөвлөж байна.

Гадаад зах зээл рүү нэвтэрсэн: Бүгд найрамдах Киргиз улс дахь Монос КейДжи ХХК-тай дистрибьютерийн гэрээ байгуулж, тухайн зах зээлд 28 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж эхлээд байна. 2024 онд өмнөх онтой харьцуулахад гадаад борлуулалт 2 дахин өссөн.